


Батлав. МУИС-ийн ХЭС-ийн  
захирал, проф.



Д.Солонго

МУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТНЫ  
ТӨГСӨЛТИЙН АЖИЛ БИЧИХ ЖУРАМ<sup>1</sup>

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Бакалаврын төгсөлтийн ажил бичих, түүнтэй холбогдон гарах бусад харилцааг зохицуулна.

1.2. МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн оюутан төгсөлтийн ажил бичихэд МУИС-ийн холбогдох дүрэм, журамд нийцэж байхын зэрэгцээ энэхүү журмыг баримтална.

1.3. Төгсөх ангийн оюутан энэ журмын хоёрт заасан болзол хангасан нөхцөлд өөрийн хүсэлт болон тухайн тэнхимиин санаачилгаар дипломын ажил бичиж болно. Төгсөлтийн ажил бичиж байгаа оюутан төгсөлтийн шалгалтын онолын хэсгээс чөлөөлөгднө.

1.4. Төгсөлтийн ажлын сэдэв нь тэнхимийн эрхлэгчийн баталсан тухайн хичээлийн жилд бичиж болох бакалаврын түвшний эрдэм шинжилгээний ажлын сэдвийн чиглэлийн хүрээнд байна.

ХОЁР. ТӨГСӨЛТИЙН АЖИЛ БИЧИХ ОЮУТАНД ТАВИХ ШААРДЛАГА

2.1. Төгсөлтийн ажлыг суралцсан хугацааны голч оноо 85 /В/ ба түүнээс дээш онооны болзол хангасан, эсхүл тухайн голч оноод хүрээгүй боловч сургууль, үндэсний, олон улсын хэмжээний оюутны эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл хэлэлцүүлж шалгарсан, эрдэм судлалын ажлын зохих арга барил эзэмшсэн оюутан бичнэ.

2.2. Энэ журмын 2.1-т заасан болзол хангасан оюутан төгсөлтийн ажил бичихийг хүсвэл тийнхүү байдлыг тодорхойлсон бичиг баримтыг Сургалтын алба, холбогдох тэнхимд гаргаж өгнө.

ГУРАВ. ДИПЛОМЫН АЖЛЫН СЭДВИЙГ БАТЛАХ, ЗАРЛАХ

3.1. Тэнхим бүр хичээлийн жилийн IX улирлын эхний хоёр долоо хоногт төгсөлтийн ажлын сэдвийн үлгэрчилсэн загвар, жагсаалтыг гаргана. Сэдвийн жагсаалтад өөр салбар эрх зүйн асуудлаар сэдэв оруулахгүй бөгөөд шаардлагатай бол тэнхимүүд хамтарсан сэдэв гаргаж болно.

<sup>1</sup> Захиргааны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 18-ний өдрийн хурлаар хэлэлцэж сайшаав

3.2. Төгсөлтийн ажлын сэдвийн үлгэрчилсэн загвар жагсаалтыг IX улирлын 10 дугаар сарын 1-ний дотор төгсөлтийн ажил бичих оюутнуудад мэдээлнэ.

3.3. Төгсөлтийн ажлын сэдэв болон бусад холбогдох мэдээллээр оюутнуудыг хангах ажлыг Сургалтын алба, холбогдох тэнхим хариуцан зохион байгуулна.

3.4. Төгсөлтийн ажил бичих болзол хангасан оюутан тухайн төгсөлтийн ажлын сэдвийн үлгэрчилсэн жагсаалттай танилцаж өөрийн бичих сэдвээ сонгож холбогдох тэнхимд мэдэгдэж бүртгүүлнэ. Хэрэв үлгэрчилсэн жагсаалтад орсон сэдвээс гадуур өөр сэдэв сонгохоор бол холбогдох тэнхимд сэдвээ бүртгүүлж төгсөлтийн ажлын сэдвийн жагсаалтад оруулна.

3.5. Холбогдох тэнхим 11 дүгээр сарын 15-ны дотор төгсөлтийн ажлын сэдвийн жагсаалтыг хурлаараа хэлэлцэж, сэдэв тус бүрээр эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг томилж, төгсөлтийн ажил бичих оюутнуудад мэдээлнэ.

3.6. Төгсөлтийн ажил бичих оюутан 12 дугаар сарын 15-ны дотор сэдвээ эрдэм шинжилгээний удирдагчаараа эцэслэн батлуулж, холбогдох тэнхимдээ бүртгүүлнэ. Төгсөлтийн ажил бичиж буй оюутан, сэдэв, удирдагчийг Сургалтын албанаас баталгаажуулна.

3.7. Удирдагч багшийн болон оюутны саналыг харгалзан төгсөлтийн ажлын сэдвийг тухайн ажлын сэдвийн ерөнхий хүрээг өөрчлөхгүйгээр нарийвчлан томъёолж болно.

3.8. Оюутны сонгосон сэдвээр сүүлийн 3 жилийн хугацаанд бакалавр, магистрын ажил бичиж хамгаалаагүй байна.

3.9. Батлагдсан нэг сэдвээр тухайн хичээлийн жилд зөвхөн нэг оюутан төгсөлтийн ажил бичиж, хамгаална.

3.10. Оюутан төгсөлтийн ажлын сэдэв, удирдагчийг өөрөө дур мэдэн өөрчлөх, сэдэв давхардуулан бичих, салбар эрх зүйн тэнхимээс баталсан сэдвээр өөр тэнхимд урьдчилсан хамгаалалт хийх, уг журамд болзол хангагүй оюутан төгсөлтийн ажил бичихийг хориглоно.

#### **ДӨРӨВ. ТӨГСӨЛТИЙН АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

4.1. Төгсөлтийн ажил нь эрх зүйн тодорхой харилцаа, бодит үйлчлэл, үзэгдэл, үзэл, онолыг задлан шинжилсэн, өөрийн шинэлэг санаа бодлыг дэвшүүлж, үндэслэл нотолгоог гаргасан, сургалт судалгааны эх сурвалжид тулгуурласан, онолын зохих түвшинтэй, оюутны бүтээлч сэтгэлгээний бичвэр байна.

4.2. Төгсөлтийн ажил нь гаднах хавтастай байхаас гадна удиртгал буюу оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй, хавсралт хэсгээс бүрдсэн байхаас гадна эрдэм шинжилгээний ажилд тавигддаг нийтлэг шаардлагыг хангасан байна.

Хавтасны нүүр хэсэгт сургууль, тэнхимиийн нэр, сэдэв, удирдагч, шүүмжлэгч, гүйцэтгэгч нарын нэрс (овог нэр, эрдмийн зэрэг, цол) он зэргийг агуулсан байна.

4.3. Төгсөлтийн ажилд социологийн судалгааг анкет, асуулгын аргаар авч (80-аас доошгүй хүнийг хамруулсан) дунг хавсаргаж болно.

4.4. Дипломын ажил нь Arial Unicode Standart (MS) фондын 12 хэмжээтэй, 50-аас доошгүй хуудастай, хуудас тус бүр зүүн тал буюу нуруулдах талаас 25 мм, дээд талаас 25 мм, баруун болон доод талаас тус бүр 20 мм авсан. Хуудасны хэмжээний шаардлагад хавсралтын хэсэг хамаарахгүй.

4.5. Төгсөлтийн ажил нь хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёо, бичилт, найрууллагаар бичигдэх ба логик системтэй, судалгааны арга зүйн шаардлага хангасан байна.

#### **ТАВ. ДИПЛОМЫН АЖЛЫГ ХАМГААЛАХ БА ҮНЭЛЭХ ЖУРАМ**

5.1 Төгсөлтийн ажлыг тогтоосон хугацаанд бичиж дуусгасан оюутан Сургалтын албанаас тогтоосон хуваарийн дагуу холбогдох тэнхимд урьдчилсан хамгаалалт хийнэ.

5.2 Тэнхимиийн хамгаалалт (урьдчилсан хамгаалалт) төгсөлтийн ажлын жинхэнэ хамгаалалт болохоос 14-21 хоногийн өмнө хийгдсэн байна.

5.3 Тэнхимиийн хамгаалалтанд орохоос 7 хоногийн өмнө төгсөлтийн ажлын 3-аас доошгүй хувийг тэнхимд өгч багш нараар уншуулсан байна.

5.4 Тэнхим оюутнуудын төгсөлтийн ажлаа хамгаалах дарааллыг тогтоож, тэнхимиийн багш нарын гуравны хоёроос доошгүй нь оролцсон хурлаар уг ажлыг хэлэлцэж, дийлэнхи олонхийн саналаар жинхэнэ (комиссын) хамгаалалтанд оруулах эсэхийг шийдвэрлэнэ. Жинхэнэ хамгаалалтад орох ажлын шүүмжлэгчийг томилж, тэнхимиийн хурлын протоколыг Сургалтын албанд ирүүлнэ.

5.5 Тэнхимээс комиссын хамгаалалтанд орох зөвшөөрөл авсан төгсөлтийн ажилд тухайн ажлын удирдагч багш тодорхойлолт бичиж ажилд хавсаргана.

5.6. Оюутан төгсөлтийн ажлыг эцсийн найруулгаар нь санал өгөх (шүүмжлэгч) багшид комисст хамгаалахаас 3-5 хоногийн өмнө өгч уншуулна.

5.7 Шүүмжлэгч багш тухайн ажлыг шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, ололтой талууд болон үнэлгээ бууруулах шалтгаан болж буй дутагдалтай талуудыг тэмдэглэн саналаа өгч үнэлнэ.

5.8. Төгсөлтийн ажил хамгаалуулах комиссыг мэргэжлийн тэнхим, профессорын багийн саналыг үндэслэн ХЗС-ийн захирлын тушаалаар томилно. Төгсөлтийн ажил хамгаалуулах комисс нь дарга, 5-7 гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэнэ. Төгсөлтийн ажил хамгаалуулах комиссыг төгсөлтийн нэгдсэн шалгалтын комисстoy нэгтгэсэн нэг комисс байгуулж болно.

5.9. Төгсөлтийн ажилд өгөх саналаа тухайн багш комиссын хамгаалалт болохоос 1 хоногийн өмнө комиссын нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

5.10. Комиссын нарийн бичгийн дарга төгсөлтийн ажил хамгаалах үед шүүмжлэгч багшийн санал, мөн тэнхимиийн хамгаалалтаас өгсөн үүрэг даалгавар, заалтыг хэрхэн хангасан болохыг харуулсан хүснэгтийг комиссын гишүүдэд уншиж сонсгоно.

5.10. Төгсөлтийн ажлыг комиссын зүгээс үнэлэхдээ нийт гишүүн бүрийн өгсөн 0-100 онооны үнэлгээний дундаж оноогоор үнэлнэ.

5.11 Урьдчилсан хамгаалалтанд хангалтгүй дүн үзүүлсэн оюутан тухайн хичээлийн жилийн төгсөлтийн шалгалтын онолын хэсгийг өгөх, эсхүл гурван жилийн дотор дахин нэг удаа хамгаалах, эсвэл онолын мэдлэг шалгах шалгалтыг өгч болно.